

ЗӨВШӨӨРСӨН:
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц. ЭРДЭМБИЛЭГ



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ХАЛДВАРТ ӨВЧИН, ТАРХВАР
СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН
“ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ЭМЧ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r)091216
ХУГАЦАА: 2 жил

Улаанбаатар хот
2022 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ :

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл

Р.Оюунгэрэл	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор
Ч. Мөнхцэцэг	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эпидемиологич, Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний холбооны гүйцэтгэх захирал, Анагаах ухааны доктор
З. Адъяасүрэн	Халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Монголын тархвар судлаачдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны доктор
Ц. Чинбаяр	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэд захирал, тэргүүлэх зэргийн эмч, Анагаах ухааны доктор
Б. Батсүх	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн чанарын менежер, Тэргүүлэх зэргийн эмч

ХАМТРАН АЖИЛЛАСАН

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл

Ц. Сэлэнгэ	Халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга
------------	--

Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл

Ж. Баярсайхан	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга
---------------	---

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл

В. Нямцэнгэл	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн ахлах багш
Г. Хоролгарав	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн багш
Э. Энэрэл	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн багш
Г. Долгорсүрэн	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн багш
Б. Мөнх-Ундрах	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн багш

ХЯНАСАН:

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр

**ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ЭМЧ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын эрүүл мэндийн, түүний дотор халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд цаашид хаана ажиллахаас үл хамааран халдварт өвчний тусламж, үйлчилгээг орчин үеийн шинжлэх ухааны нотолгоонд суурилан мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх чадамжтай халдвартын эмч бэлтгэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/447 дугаар “Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалаар “Халдварт өвчин судлалын эмч”-ийн үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг шинэчлэн баталсан ба Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/337 дугаар тушаалын 2.5.1.2-т “Хүний их эмчийн бусад үндсэн мэргэшлийн сургалт нь гурваас доошгүй жилийн хугацаатай бөгөөд сургалтын нэг жил нь журмын 2.5.1.1-д заасан ерөнхий мэргэшил судлалын сургалт байна” гэж заасны дагуу энэхүү хөтөлбөрийг 2 жилийн хугацаатайгаар, 2019 оны 6-р сарын 3-ны өдрийн ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтэний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 6-р сарын 3-ны өдрийн хурлын №1 тогтоол “Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн А/226 дугаар тушаалаар батлагдсан “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмын шаардлагад нийцүүлэн боловсруулав.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцэх халдварт өвчин судлалын тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий халдварт өвчин судлалын эмч бэлтгэх

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Халдварт өвчин судлалын эмчийн үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:

Монгол улсын хүн амд халдварт өвчний үеийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; Монгол улсад зонхилон тохиолддог болон шинэ ба сэргэж буй халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, сэргийлэлтийг орчин үеийн шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан зохион байгуулдаг төдийгүй эмнэлгийн бусад мэргэжилтэнүүдэд халдварт өвчний чиглэлээр зөвлөж сургах, хүн амд халдварт өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийг боловсрол олгох мэдлэг чадвар хандлага эзэмшсэн; эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйг чандлан баримталдаг; багаар ажиллан халдварт өвчний тусламж үйлчилгээг хүн амд чанартай хүргэдэг; халдварт өвчний тохиолдлын үед халдвар судлалын анхан шатны арга хэмжээг хэрэгжүүлж чаддаг; халдварт өвчин судлалын төрөлжсөн нарийн мэргэжлээр цаашид мэргэших чадавхитай үндсэн мэргэшлийн эмч байна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН “ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ЭМЧ”-ИЙН ЦӨМ ЧАДАМЖ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. Халдварт өвчин судлалын эмч (*Infectious Disease Physician*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөх (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Чадамж (*Competency*): Эмнэлгийн мэргэжилтэний мэдлэг, ур чадвар, үнэ цэн, хандлага зэрэг олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан, ажиглагдахуйц хүчин чадал-чадвар. Нэгэнт чадамж нь харагдахуйц тул түүнийг хэмжиж, эзэмшсэн эсэхийг үнэлж болно. Барилгын тоосгыг өрж угсрахтай адил чадамжийг хэрхэн эзэмших, хөгжихийг зааж чиглүүлж болно.

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Цөм чадамж бүхий халдварт өвчин судлалын эмчийг бэлтгэхэд сургалтын зорилт оршино. Үүний тулд дараах дэд чадамжийг эзэмшсэн байна.

1. Халдварт өвчин судлалын эмч (*Infectious Disease Physician*)

- Монгол оронд зонхилон тохиолддог төдийгүй шинэ болон сэргэж буй халдварт өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах, сэргийлэх үйл ажиллагааг эмнэлгийн тусламж үйлчилгээний бүхий л шатанд бие даан хэрэгжүүлэх
- Халдварт өвчний тохиолдол, дэгдэлт, тахалт дэгдэлт, түүнчлэн Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд халдвар судлалын анхан шатны сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Халдварт өвчний чиглэлээр судалгаа шинжилгээ хийх
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох
- Халдварын сэргийлэлт хяналтын дүрмийг мөрдөх
- Ёс суртахууныг эрхэмлэх
- Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйг сахих

2. Мэргэжлийн байх (*Professional*)

- “Хүний их эмч”-ийн мэргэжлийн чадамжтай байх
- “Ерөнхий мэргэжлийн эмч”-ийн чадамжтай байх
- Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх хүсэл эрмэлзлэлтэй, санаачлагатай байх
- Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний салбарт халдварт өвчин судлалын салбарыг хөгжүүлэх хүсэл эрмэлзлэл, санаачлагатай байх
- Эмнэлгийн бусад мэргэжилтэнүүдэд халдварт өвчний чиглэлээр зөвлөж сургах
- Хүн амд халдварт өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийг боловсрол олгох сургалтыг зохион байгуулах

3. Суралцагч (*Learner*)

- Хүнлэг энэрэнгүй хандлагыг өдөр тутмын үйл ажиллагаанд дадуулах
- Байгууллагын соёлыг сайжруулахад суралцах
- Шинжлэх ухааны ололт амжилтаас бие даан тасралтгүй суралцаж халдварт өвчин судлалын эмчийн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх
- Мэргэжлийн болон нийгмийн харилцааны чиглэлээр өөрийн түвшинг тодорхойлж өөрөө өөрийгөө хөгжүүлэх хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах
- Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтанд тогтмол хамрагдах
- Мэргэжлийн бүхий үйл ажиллагаандаа халдварын сэргийлэлт хяналтыг мөрдөх дадалд суралцах
- Бусадтай мэдээлэлээ хуваалцах хандлагад суралцах
- Багийн гишүүдийн амжилт, эерэг хандлагаас суралцах
- Мэргэжлийн алдаанаас зайлсхийхэд суралцах
- Мэргэжлийн шалтгаант ажлаас халшрах хамшинж зэрэг сэтгэлзүйн дарамтаас зайлсхийхэд суралцах

4. Харилцагч (*Communicator*)

- Нийгмийн харилцаанд хүндлэг энэрэнгүй хандлагаар харилцах
- Үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан халдварт өвчний асуудлыг тайлбарлан таниулах
- Багийн гишүүддээ ёс зүйтэй хандах
- Бусдад сэтгэлзүйн эерэг дэмжлэг үзүүлэх
- Багийн гишүүд болон бусад мэргэшлийн мэргэжилтэнүүдэд халдварт өвчний талаар зөвлөж сургах
- Бусдыг халдварын сэргийлэлт хяналтын дүрмийг зөрчихөөс сэргийлж анхааруулах

5. Хамтрагч (*Collaborator*)

- Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд багийн гишүүдтэй хамтран ажиллах
- Халдварт өвчний тусламж үйлчилгээг чанартай зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгуулагатай хамтран ажиллах
- Халдварт өвчний асуудлыг багийн гишүүд болон эрүүл мэндийн болон эмнэлгийн бусад мэргэшлийн мэргэжилтэнтэй хамтран шийдвэрлэх
- Халдварын сэргийлэлт хяналтыг мөрдөхөд эмнэлгийн бусад мэргэшлийн мэргэжилтэнүүдэд туслах
- Шинжлэх ухааны ололт амжилтыг багийн гишүүд суралцахад хамтран ажиллах
- Халдварт өвчний үеийн нийгмийн ноцтой байдал үүссэн үе буюу халдварт өвчний дэгдэлт, тахал, цартахлын үед төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллах
- Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр олон нийт, хүн амтай хамтран ажиллах

6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөх (*Community Health Advocate*)

- Хүн амд халдварт өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох
- Хүн амд халдварт өвчний дэгдэлт, тахал, цартахлын үед мөрдөх журмыг тайлбарлан таниулах, зөвлөх

- Үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан халдварт өвчний асуудлыг тайлбарлан таниулах, дэмжих

7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader)

- Байгууллагын соёлыг сайжруулахад үлгэрлэн ажиллах
- Халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний бүхий л шатанд мэргэжлийн үүднээс зохион байгуулах
- Халдварт өвчний тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд манлайлан ажиллах
- Хүн амд халдварт өвчнөөс сэргийлэх, халдварт өвчний тухай эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалтанд халдварт өвчний эмнэлзүй, халдварт өвчний тархвар судлал, халдварт өвчний бичил амь судлал, дархлал судлал, халдварт өвчний лабораторийн оношилгоо, дотор өвчин судлал түүний дотор хоол боловсруулах эрхтэн судлал, уушги судлал, цус судлал, хавдар судлал, эмнэлзүйн эм судлал, хүүхэд судлал, арьс судлал гэсэн чиглэлүүдээр тойролт заавал хийж, халдварт өвчний тусламж үйлчилгээний сургалт болон сонгон суралцах чиглэлээр сургалтанд хамрагдана.
- Сургалтын хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг сургалтын байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Эмнэлзүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг хангаж, Эмнэлгийн мэргэжилтэний хөгжлийн зөвлөлөөс “Халдварт өвчин судлалын эмч”-ийн үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан сургалт эрхлэх болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага энэхүү сургалтыг явуулна.
- Сургалт явуулах хангалттай орчин бүрдээгүй тохиолдолд эрүүл мэндийн бусад байгууллагыг оролцуулан сургалтын байгууллагын сүлжээ үүсгэн хамтарч ажиллана.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтанд заавал хамрагдана.
- Сургалтын хугацаанд орон нутагт 1 сараас доошгүй хугацаагаар тойролт хийж болно.
- Сонгон суралцах чиглэлийг сургалт эрхлэх байгууллагаас сонгох ба сургалтын хугацаа нь 1 сар хүртэл байна.
- Сурагцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хувиарийг сургалт эрхлэх байгууллагаас боловсруулж батална.
- Сургалтыг эмнэлгийн байгууллагын тасаг нэгж, сургалтын танхимд зохион байгуулна.

6.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, гардан үйлдэл
Сургалтын төгсгөлд цөм чадамж бүхий халдварт өвчин судлалын эмчийг бэлтгэн гаргахын тулд сургагч багшийн хяналтан дор халдварт өвчний үеийн дараах шинж тэмдэг, гардан үйлдлийг үндсэн мэргэшлийн түвшинд бие даан хийж гүйцэтгэх туршлагыг хуримтлуулна.

6.2.1. Шинж тэмдэг (*signs and symptoms*) (эмнэлзүйн болон тархвар судлалын тойролтонд хамаарах)

Халдварт өвчнийг шинж тэмдэг, хамшинж дээр үндэслэн эрт илрүүлэх, сэжиглэх, магадлах, батлах (оношлох), эмчлэх, хянах, халдварын голомтонд тархвар судлалын анхан шатны арга хэмжээг хэрэгжүүлж чаддаг болох

1. Халдварын шалтгаант халууралт (*Fever caused by infectious*)
2. Халдварын шалтгаант амьсгалын замын үрэвсэл (*Respiratory inflammation caused by infection*)
3. Халдварын шалтгаант шарлалт (*Jaundice caused by infectious*)
4. Халдварын шалтгаант суулгалт (*Diarrhea caused by infectious*)
5. Халдварын шалтгаант тууралт (*Rash caused by infectious*)
6. Халдварын шалтгаант менингит, энцефалит, миелит, невритийн хамшинж (*Meningitis, Encephalitis, myelitis, neuritis syndrome caused by infectious*)
7. Халдварын шалтгаант тунгалагийн булчирхайн томролт (*Lymphadenitis caused by infectious*)
8. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (*Health care associated infection*)
9. Халдварын сэргийлэлт хяналт (*Infection control and prevention*)

6.2.2. Өвчин (эмнэлзүйн болон тархвар судлалын тойролт тус бүрээр)

1. Монгол улсад зонхилон тохиолддог бөгөөд монгол улсын хэмжээнд албан ёсоор бүртгэгддэг халдварт өвчнийг эрт илрүүлж, сэжиглэж, магадлаж, баталж-оношлож, эмчилж чаддаг болох
2. Шинэ болон сэргэж буй халдварт өвчнийг эрт илрүүлж, сэжиглэж, магадлаж, баталж-оношлож, эмчилж чаддаг болох
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг эрт илрүүлж, сэжиглэж, магадлаж, баталж-оношлож, эмчилж чаддаг болох
4. Халдварт өвчний тохиолдол бүрт тархвар судлалын анхан шатны арга хэмжээг эмнэлгийн тусламжийн шатлал бүрт, хүн амын дунд зохион байгуулж чаддаг болох
5. Халдварт өвчин тус бүрт халдварын сэргийлэлт хяналтыг хэрэгжүүлж сурах
6. Халдварт бус өвчний тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн болон эмнэлгийн байгууллагад халдварын сэргийлэлт хяналтыг хэрэгжүүлэхэд зааж сургах, зөвлөж чаддаг болох
7. Эмнэлэг хоорондын үйл ажиллагааны дүрэм журмыг хэрэгжүүлж чаддаг болох
8. Халдварт өвчтэй тохиолдол түүний гэр бүл, хамт олон, нийгэмд халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөгөө өгөх, зааж сургахад суралцах

Халдварт өвчнүүд (Certain infectious and parasitic diseases) A00-B99

Гэдэсний халдварт өвчин (Intestinal infectious diseases or food borne and water-borne infectious diseases)

1. Урвах тахал (*Cholera*) **A00.0-A00.9**
2. Балнад болон иж балнад (*Typhoid and paratyphoid fever*) **A01.0-A01.4**
3. Салмонеллез болон салмонеллийн халдвар (*Salmonellosis and other salmonella infections*) **A02.0-A02.9**
4. Цусан суулга (*Dysentery or Shigeliosis*) **A03.0-A03.9**
5. Эшерихийн халдвар (*Escherichia coli infection*) **A04.0-A04.4**
6. Кампилобактерийн халдвар **A04.5**
7. Гэдэсний иерсиноз (*Intestinal yersinosis*) **A04.6**
8. *Clostridium difficile* -р үүсгэгдсэн энтероколит буюу хоолны хордлого (*Foodborne intoxication or enterocolitis due to Clostridium difficile*) **A04.7**
9. Бусад бактерийн шалтгаант гэдэсний халдварт өвчин (*Other bacterial intestinal infection*) **A04.8-A04.9**
10. Стафилококкоор үүсгэгдсэн хоолны хордлого (*Foodborne staphylococcal intoxication*) **A05**
11. Хиамдал (*Botulism*) **A05.1**
12. *Clostridium perfringens* -р үүсгэгдсэн хоолны хордлого (*Foodborne intoxication by Clostridium perfringens*) **A05.2**
13. *Bacillus cereus* -р үүсгэгдсэн хоолны хордлого (*Foodborne intoxication by Bacillus cereus*) **A05.4**
14. Хоолны хордлого шалтгаан тодорхойгүй (*bacterial foodborne intoxication specified and unspecified*) **A05.8-A05.9**
15. Амебиоз (*Amoebiasis*) **A06.: A06.0-A06.9**
16. Ротавируст халдвар (*Rotaviral infection*) **A08.0**
17. Вирусийн шалтгаант гэдэсний халдварт өвчин: норовирусийн шалтгаант **A08.1**, аденовирусийн шалтгаант **A08.2**, бусад **A08.3**, шалтгаан тодорхойгүй **A08.4** (*Viral intestinal infection: acute gastroenteropathy due to Norovirus, adenoviral enteritis, other viral enteritis, viral intestinal infection, unspecified*)
18. Шалтгаан тодорхойгүй гэдэсний халдварт өвчин (*Other gastroenteritis and colitis of infectious and unspecified origin*) **A09: A09.0 and A09.9**
19. Цочмог вирүст хепатит А (*Acute viral hepatitis A*) **B15: B15.0-B15.9**
20. Цочмог вирүст хепатит Е (*Acute viral hepatitis E*) **B17.2**
21. Халдварт саа (*Poliomyelitis*) **A80: A80.0-A80.9**
22. Энтеровируст халдвар: Энтеровируст менингит **A87.0**, энтеровируст энцефалит **A85.0†** (*Enteroviral infection: Enteroviral meningitis, enteroviral encephalomyelitis G05.1*)
23. Энтеровируст халдвар, байрлал тодорхой бус (*Enterovirus infection, unspecified site*) **B34.1**

Амьсгалын замын халдварт өвчин (Respiratory infectious diseases)

1. Сүрьеэ (*Tuberculosis*) **A15-A19**
2. Сахуу (*Diphtheria*) **A36: A36.0-A36.9**
3. Хөхүүл ханиад (*Whooping cough*) **A37: A37.0-A37.9**
4. Улаан эсэргэнэ (*Scarlet fever*) **A38**
5. Менингококкт халдвар (*Meningococcal infection*) **A39: A39.0-A39.9**

6. *Haemophilus influenzae*-р үүсгэгдсэн халдварт өвчин (*Haemophilus influenzae infection, unspecified*) **A49.2**
7. Микоплазмаар үүсгэгдсэн халдвар (*Mycoplasma infection, unspecified site*) **A49.3**
8. Амьсгалын дээд замын цочмог халдвар (*Acute upper respiratory infections*) **J00-J06**
9. Томуу ба хатгаа (*Influenza and pneumonia*) **J09-J18**
10. Амьсгалын доод замын бусад халдвар (*other acute lower respiratory infections*) **J20-J22**
11. Аденовирүсийн халдвар: аденовирүст менингит-**A87.1**, аденовирүст энцефалит-**A85.1** (*Adenoviral infection: adonoviral meningitis – G02.0, adonoviral encephalitis G025.1*)
12. Аденовирүст халдвар, байрлал тодорхой бус (*Adenovirus infection, unspecified site*) **B34.0**
13. Амьсгалын цочмог халтай хам шинж буюу АЦХаХ (*Severe acute respiratory syndrome - SARS*) **U04.9**
14. КОВИД-19 **U00, U49** (*COVID-19, virus identifies (U07.1), COVID-19, virus not identified (U07.2)*) **U07.1-U07.2**
15. Гахай хавдар (*Mumps*) **B26: B26.0-B26.9**

Цусаар дамждаг халдварт өвчин (*Blood-borne infectious diseases*)

1. Цочмог вирүст хепатит В (*Acute viral hepatitis B*) **B16: B16.0-B16.9**
2. Архаг вирүст хепатит В ба D (*Chronic viral hepatitis B with delta agents*) **B18.0**
3. Архаг вирүст хепатит В (*Chronic viral hepatitis B without delta agents*) **B18.1**
4. Цочмог вирүст хепатит С (*Acute viral hepatitis C*) **B17.1**
5. Архаг вирүст хепатит С (*Chronic viral hepatitis C*) **B18.2**
6. Цочмог вирүст хепатит D (*Acute delta –(super) infection in chronic hepatitis B*) **B17.0**
7. ХДХВ/ДОХ (*HIV/AIDS*) **B20-B24**

Тууралтат халдварт өвчин (*Viral infections characterized by skin and mucous membrane*) **B00-B09 and A38-39**

1. Херпес вирүсийн халдвар (*Herpes viral infection*) **B00:**
 - 1.1. Энгийн херпес вирүсийн халдвар-1 (*Herpes viral infection or herpes simplex-1 viral infection*) **B00.1-B00.2**
 - 1.2. Херпес вирүст менингит (*Herpes viral meningitis-G02.0*)) **B00.3†**
 - 1.3. Херпес вирүст энцефалит (*Herpes viral encephalitis-G05.1*)) **B00.4†**
 - 1.4. Нүдний херпес (*ocular herpes*) **B00.5**
 - 1.5. Херпесийн вирүсийн бусад халдвар **B00.7-B00.9** (*Other forms herpes viral infection*)
2. Салхин цэцэг (*Chicken pox and shingles*) **B01: B01.0-B01.9**
3. Бүслүүр үлд (*Zoster or herpes zoster*) **B02: B02.0-B02.9**
4. Улаан бурхан (*Measles*) **B05: B05.0-B05.9**
5. Улаанууд (*Rubella or German measles*) **B06: B06.0-B06.9**
6. Розеола (*Exanthema subitem [sixth disease]*) **B08.2**
7. Халдварт эритема (*Erythema infectiousum [fifth disease]*) **B08.3**
8. Гар хөл амны өвчин (*Hand, foot and mouth diseases*) **B08.4**
9. Герпангина (*Herpangina*) **B08.5**
10. Энтеровирүст тууралтат халдвар (*Enteroviral exanthematous fever*) **A88**
11. Улаан эсэргэнэ (*Scarlet fever*) **A38**

12. Менингококкт халдвар (*Meningococcal infection*) A39: A39.0-A39.9

Зоонозын халдварт өвчин A20-A28 (*Certain zoonotic diseases*)

1. Тарваган тахал (*Plague*) **A20: A20.0-A20.9**
2. Боом (*Anthrax*) **A22: A22.0-A22.9**
3. Бруцеллез (*Brucellosis*) **A23: A23.0-A23.9**
4. Лептоспироз (*Leptospirosis*) **A27: A27.0-A27.9**
5. Гэдэсний иерсиноз (*Intestinal yersinosis*) **A04.6 (Excl.: A28.2)**
6. Хуурамч сүрьеэ (*Pseudotuberculosis extraintestinal yersinosis*) **A28.2**
7. Татран (*Tetanus*) **A33-A35**
8. Хачигт боррелиоз буюу *Borrelia burgdorferi*-р үүсгэгдсэн Лаймын өвчин (*Tick-borne borreliosis or Lyme disease or Erythema chronicum migrans due to Borrelia burgdorferi*) **A69.2**
9. Хачигт риккетсиоз (*Tick-borne rickettsiosis*) **A77: A77.0-A77.9**
10. Ку халууралт (*Q fever*) **A78**
11. Галзуу (*Rabies*) **A82: A82.0-A82.9**
12. Хачигт энцефалит (*Tick-borne encephalitis*) **A84: A84.0-A84.9**
13. Шүлхий (*Foot and mouth diseases*) **B08.8**
14. Токсоплазмоз (*Toxoplasmosis*) **B58: B58.0-B58.9**
15. Бабезиоз (*Babesiosis*) **B60.0**

Арьсны халдварт өвчин (*Skin infectious diseases*)

1. Хамуу (*Scabies*) **B86**
2. Хийт үхжил (*Gas gangrene*) **A48.0**
3. Елом (*Erysipelas*) **A46**
4. Мөөгөнцрийн халдвар (*Candidiasis*) **B37: B37.0-B37.9**
5. Херпес вирүсийн халдвар: Энгийн херпес вирүсийн халдвар-1 (*Herpes viral infection or herpes simplex-1 viral infection*) **B00.1**

Дамжуулагчаар дамждаг халдварт өвчин (*Vector-borne diseases*)

1. Хумхаа (*malaria*) **B50-B54**
2. Хачигт боррелиоз буюу *Borrelia burgdorferi*-р үүсгэгдсэн Лаймын өвчин (*Tick-borne borreliosis or Lyme disease or Erythema chronicum migrans due to Borrelia burgdorferi*) **A69.2**
3. Хачигт риккетсиоз (*Tick-borne rickettsiosis*) **A77: A77.0-A77.9**
4. Хачигт энцефалит (*Tick-borne encephalitis*) **A84: A84.0-A84.9**

Бэлгийн замаар дамжих халдварт өвчин A50-A64 (*Sexually transmitted infectious diseases or Infections with a predominantly sexual mode of transmission*)

1. Тэмбүү (*Syphilis*) **A50-A53**
2. Заг хүйтэн (*Gonorrhea*) **A54: A54.0-A54.9**
3. Хламидийн халдвар (*Venerum or chlamydial infection*) **A55-A56**
4. Трихомониаз (*Trichomoniasis*) **A59: A59.0-A59.9**
5. ХДХВ/ДОХ (*HIV/AIDS*) **B20-B24**
6. Бэлгийн херпес (*Herpes viral infection genitalia and urogenital tract or herpes simplex-2 viral infection*) **A60: A60.0-A60.9**

Үжил A40-A41:A40.0-A40.9 and A41.0-A41.9 (Sepsis)

Гелминтийн халдвар B65-B83 болон Шимэгчийн халдвар B90-B94 (Helminthiases and Parasitic diseases)

1. Эхиноккоз (*Echinococcosis*) **B67: B67.0-B67.9**
2. Гахайн туузан хорхойтох өвчин (*Pork tapeworm infection or Taenia solium taeniasis*) **B68.0**
3. Үхрийн туузан хорхойтох өвчин (*Beef tapeworm infection or Taenia saginata taeniasis*) **B68.1**
4. Аскаридоз (*Ascariasis*) **B77: B77.0-B77.9**
5. Энтеробиоз (*Enterobiasis*) **B80**
6. Бөөстөх (*Pediculosis and phthiriasis*) **B85: B85.0-B85.4**

Бусад халдварт өвчин B25-B34 ба халдварт өвчин үүсгэгч B95-B99 (Other infectious diseases and Bacterial, viral and other infectious agents): B95-B99 код бүхий эмгэг нь өвчний эхний оношийн кодоод орохгүй бөгөөд зөвхөн үүсгэгчийг тодорхойлсон үед энэхүү кодыг ашиглана.

1. Цитомегаловируст өвчин (*Cytomegaloviral diseases*) **B25: B25.0-B25.9**
2. Халдварт моноклеоз (*Infectious mononucleosis*) **B27: B27.0-B27.9**
3. Аденовируст халдвар, байрлал тодорхой бус (*Adenovirus infection, unspecified site*) **B34.0**
4. Энтеровируст халдвар, байрлал тодорхой бус (*Enterovirus infection, unspecified site*) **B34.1**
5. Коронавируст халдвар, байрлал тодорхой бус: АЦХаХ (SARS) **U04.9** болон КОВИД-19 **U07.1-U07.2** хамаарахгүй (*Coronavirus infection, unspecified site: Excl.: COVID-19, virus identifies (U07.1), COVID-19, virus not identified (U07.2)*) **B34.2:**
6. Парвовируст халдвар, байрлал тодорхой бус (*Parvovirus infection, unspecified site*) **B34.3**
7. Зика вируст өвчин (*Zika virus diseases*) **A92.5**
8. Эбола вируст өвчин (*Ebola virus diseases*) **A98.4**
9. Стафилококкоор үүсгэгдсэн халдвар (*Staphylococcal infection, unspecified site*) **A49.0**
10. Стрептококкоор үүсгэгдсэн халдвар (*Streptococcal infection, unspecified site*) **A49.1**
11. Хламидийн халдвар (*Other diseases caused by chlamydiae*) **A70-A74**
12. Халдвар үүсгэгч бактери (*Other specified bacterial agents as the cause of diseases classified to other chapters*) **B96:**
 - 12.1. Стрептококк болон стафилококк (*Streptococcus and staphylococcus as the cause of diseases classified to other chapters*) **B95: B95.0-B95.9**
 - 12.2. *Mycoplasma pneumoniae* [*M. pneumoniae*] (*Mycoplasma pneumoniae* [*M. pneumoniae*] as the cause of diseases classified to other chapters) **B96.0** Pleuro-pneumonia-like-organism [PPLO]
 - 12.3. *Klebsiella pneumoniae* [*K. pneumoniae*] (*Klebsiella pneumoniae* [*K. pneumoniae*] as the cause of diseases classified to other chapters) **B96.1**
 - 12.4. *Escherichia coli* [*E. coli*] (*Escherichia coli* [*E. coli*] as the cause of diseases classified to other chapters) **B96.2**
 - 12.5. *Haemophilus influenzae* [*H. influenzae*] (*Haemophilus influenzae* [*H. influenzae*] as the cause of diseases classified to other chapters) **B96.3**

- 12.6. *Pseudomonas (aeruginosa) (Pseudomonas (aeruginosa) as the cause of diseases classified to other chapters) B96.5*
- 12.7. *Clostridium perfringens [C. perfringens] (Clostridium perfringens [C. perfringens] as the cause of diseases classified to other chapters) B96.7*
- 12.8. *Хеликобактери (Helicobacter pylori [H.pylori] as the cause of diseases classified to other chapters) B98.0*
- 13. *Халдвар үүсгэгч вирус (Other specified viral agents as the cause of diseases classified to other chapters) B97:*
 - 13.1. *Аденовирус (Adenovirus as the cause of diseases classified to other chapters) B97.0*
 - 13.2. *Энтеровирус (Enterovirus as the cause of diseases classified to other chapters) B97.1*
 - 13.3. *Коронавирус (Coronavirus as the cause of diseases classified to other chapters) B97.2*
 - 13.4. *Респиратор-синцитиаль вирус (Respiratory syncytial virus as the cause of diseases classified to other chapters) B97.4*
 - 13.5. *Парвовирус (Parvovirus as the cause of diseases classified to other chapters) B97.6*
 - 13.6. *Хүний метапневмовирус (Human metapneumovirus as the cause of diseases classified to other chapters) B97.8*
- 14. *Ургийн халдвар (Infections specific to the perinatal period) P35-39*

Шалтгаан тодорхойгүй шинэ халдварт өвчин буюу нийгмийн ноцтой байдал үүссэн тохиолдол (*Provisional assignment of new diseases of uncertain etiology or emergency use*) **U00-U49**

- 1. *КОВИД-19 өвчнөөр өвдсөн түүхтэй (Personal history of COVID-19) U08: U08.9*
- 2. *КОВИД-19-ийн дараах байдал (Post COVID-19 condition) U09*
- 3. *КОВИД-19-тэй холбоотой олон эрхтэний эмгэгийн хамшинж (Multisystem inflammatory syndrome associated with COVID-19, unspecified) U10: U10.9*
- 4. *КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалт (Need for immunization against COVID-19, unspecified or Prophylactic COVID-19 vaccination) U11: U11.9*
- 5. *КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтын гаж нөлөө буюу хариу урвал (COVID-19 vaccinees causing adverse effects in therapeutic use, unspecified) U12: U12*
- 6. *Нийгмийн ноцтой байдал үүссэн тохиолдол, шалтгаан тодорхойгүй (Emergency use) U13-U49*

Бичил биетийн эсрэг эмэнд тэсвэрэй (*Resistance to antimicrobial drugs*) **U82-U84.9**

Тайлбар: Энэ тохиолдолд B95-B98 кодыг нэмэлтээр ашиглана.

- 1. *Беталактамын антибиотикт тэсвэртэй (Resistance to betalactam antibiotics) U82*
 - 1.1. *Пенициллины бүлэгт (амоксициллин, ампициллин) тэсвэртэй (Resistance to penicillin [amoxicillin, ampicillin] U82.0*
 - 1.2. *Метициллины бүлэгт (клоксациллин, флюклоксациллин, оксациллин) тэсвэртэй (Resistance to methicillin [cloxacillin, flucloxacillin, oxacillin] U82.1*
 - 1.3. *Өргөн үйлдэлт беталактамаз тэсвэртэй (Extended spectrum betalactamase [ESBL] resistance) U82.2*

- 1.4. Бусад беталактамьн антибиотикт тэсвэртэй (*Resistance to other betalactam antibiotics*) **U82.8**
- 1.5. Беталактамьн антибиотикт тэсвэртэй, тодорхойгүй (*Resistance to betalactam antibiotics, unspecified*) **U82.9**
2. Бусад антибиотикт тэсвэртэй (*Resistance to other antibiotics*) **U83**
 - 2.1. Ванкомицинд тэсвэртэй (*Resistance to vancomycin*) **U83.0**
 - 2.2. Ванкомицинтэй холбоотой антибиотикт тэсвэртэй (*Resistance to other vancomycin related antibiotics*) **U83.1**
 - 2.3. Квинолонд тэсвэртэй (*resistance to quinolones*) **U83.2**
 - 2.4. Олон антибиотикт тэсвэртэй (*Resistance to multiple antibiotics*) **U83.7**
 - 2.5. Дан өвөрмөц антибиотикт тэсвэртэй (*Resistance to other single specified antibiotics*) **U83.8**
 - 2.6. Тодорхой бус антибиотикт тэсвэртэй (*Resistance to unspecified antibiotics*) **U83.8**
3. Бусад бичил биетийн эсрэг эмэнд тэсвэртэй (*Resistance to other antimicrobial drugs*) **U84**
 - 3.1. Паразитийн эсрэг эмэнд тэсвэртэй (*Resistance to antiparasitic drugs*) **U84.0**
 - 3.2. Мөөгний эсрэг эмэнд тэсвэртэй (*resistance to antifungal drugs*) **U84.1**
 - 3.3. Вирүсийн эсрэг эмэнд тэсвэртэй (*Resistance to antiviral drug*) **U84.2**
 - 3.4. Сүрьеэгийн эсрэг эмэнд тэсвэртэй (*Resistance to tuberculostatic drugs*) **U84.3**
 - 3.5. Олон эмэнд тэсвэртэй (*resistance to multiple antimicrobial drugs*) **U84.7**
 - 3.6. Бусад тодорхой антибиотикт тэсвэртэй (*Resistance to other specified antimicrobial drugs*) **U84.8**
 - 3.7. Тодорхой бус бичил биетийн эсрэг эмэнд тэсвэртэй (*Resistance to unspecified antimicrobial drugs*) **U84.9**

Халдварт бус өвчнүүд

Хавдар (*Neoplasms*)

1. Нарийн гэдэсний хорт хавдар (*Malignant neoplasms of small intestine*) **C17**
2. Бүдүүн гэдэсний хорт хавдар (*Malignant neoplasms of colon*) **C18**
3. Элэгний хорт хавдар (*Malignant neoplasms of liver and intrahepatic bile ducts*) **C22**
4. Цэсний хүүдийн хорт хавдар (*Malignant neoplasms of gallbladder*) **C23**
5. Нойр булчирхайн хорт хавдар (*Malignant neoplasms of pancreas*) **C25**
6. Уушигны хорт хавдар (*Malignant neoplasms of bronchus and lung*) **C34**
7. Арьсны хорт хавдар (*Melanoma and other malignant neoplasms of skin*) **C43-C44**
8. Төв мэдрэлийн тогтолцоо, тархи, нүдний хорт хавдар (*Malignant neoplasms eye, brain and other parts of central nervous system*) **C69-C72**
9. Тунгалагийн булчирхайн хорт хавдар (*Malignant neoplasms of lymphoid, hematopoietic and related tissue*) **C81-C96**

Дотор өвчин судлал

1. Цусны өвчин: Цусны бүлэгнэлтийн эмгэг, цусан тууралт болон бусад цусархаг хамшинж (*Coagulation defects, purpura and other hemorrhagic conditions*) **D65-D69**
2. Мэдрэлийн тогтолцооны өвчин (*Diseases of nervous system*) **G00-G99**
3. Хоол боловсруулах замын өвчин (*Diseases of the digestive system*):
 - 3.1. Халдварын бус шалтгаант энтерит ба колит (*Noninfective enteritis and colitis*) **K50-K52**

3.2. Элэгний өвчин (*Diseases of liver*) K70-K77

Хүүхдийн өвчин

1. Ургийн халдвар (*Infections specific to the perinatal period*) P35-39

6.2.3. Гардан үйлдэл

1. Эмчийн үзлэг хийх
2. Үйлчлүүлэгчдэд ялган ангилалт болон эрэмбэлэн ангилалт хийх
3. Дүрс оношилгооны зурагт анхан шатны уншилт хийх
4. Лабораторийн шинжилгээнд сорьц авах
5. Ходоод угаах
6. Ходоодонд хаймсуур тавих
7. Бургуй тавих
8. Давсганд гуурс тавих
9. Ходоодны цус тогтоох
10. Нугасны хатгалт хийх
11. Судасны хүрц
12. Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор) (ялангуяа нярай, бага насны хүүхдэд)
13. Судсаар эмчилгээг 24 цагийн турш хийх тооцоолол хийх
14. Амилуулсан суурь тусламж үзүүлэх
15. Инвазив бус зохиомол амьсгал хийх
16. Хүчилтөрөгчөөр амьсгалуулах (маск болон хамрын ац гуурс)
17. Цусан дах сахарыг тодорхойлох
18. Вакцины урвал хүндрэлийг хянах
19. Амьсгалын зам чөлөөлөх энгийн арга
20. Оёдол тавих (цус тогтоох, шарх цэгцлэх)
21. ЭМС-ын тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллага, эмнэлэгт ашиглах холбогдох бичиг баримт, маягыг хөтлөх, цахим мэдээллийн санг хөтлөх
22. Судалгааны аргазүйн ерөнхий мэдлэг эзэмшисний үндсэн дээр эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэх бичих боловсруулах, хэвлүүлэх

Тойролтын хуваарь (*Clinical rotation schedule*)

№	Тойролтын сэдэв	Тойролтын хугацаа /долоо хоногоор/	Сургалт зохион байгуулах газар
1.	Амьсгалын замын халдварт өвчин	6	Ажлын байрны сургалт Халдварт өвчин судлалын үндэсний төв
2.	Гэдэсний халдварт өвчин	6	
3.	Насанд хүрэгсэдийн хепатит /цочмог/	6	
4.	Хүүхдийн цочмог хепатит	4	

5.	Архаг вирус хепатит	5	
6.	Зоонозын халдвар	4	
7.	Тууралтат халдварт өвчин	6	
8.	Халдварын сэргийлэлт хяналт	4	
9.	Бэлгийн замаар дамжих халдвар /ХДХВ/ДОХ	4	
10.	Сүрьеэ	4	
11.	Шинэ болон сэргэж буй халдвар	4	
12.	Хүлээн авах, яаралтай тусламж	6	
13.	Халдварт өвчний үеийн эгзэгтэй байдал	6	
14.	Арьсны өвчин	2	Ажлын байрны сургалт Арьсны өвчин судлалын үндэсний төв
15.	Дүрс оношилгоо	4	Ажлын байрны сургалт Халдварт өвчин судлалын үндэсний төв Монгол Японы эмнэлэг
16.	Хүүхдийн өвчин	2	Ажлын байрны сургалт Монгол Японы эмнэлэг
17.	Дархлал судлал	2	Танхимын сургалт
18.	Бичил амь судлал	2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
19.	Хавдар судлал	2	Ажлын байрны сургалт Хавдар судлалын үндэсний төв
20.	Дотор судлал: цус судлал, уушги судлал, дотоод шүүрэл судлал-чихрийн шижин	4	Ажлын байрны сургалт Халдварт өвчин судлалын үндэсний төв Монгол Японы эмнэлэг
21.	Эмнэлзүйн эм судлал	1	Танхимын сургалт Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
22.	Халдварт өвчний диспансерчлал буюу хяналт	4	Ажлын байрны сургалт Халдварт өвчин судлалын үндэсний төв
Нийт		88	

Сургалтын агуулга:

Тойролт 1: Амьсгалын замын халдварт өвчин

Монгол улсад болон дэлхий дахинаа тохиолдож буй агаар дуслын замаар дамжин халдварладаг амьсгалын замын халдварт өвчин (вирус болон бактерийн шалтгаант ТТӨ, сахуу, хөхүүл ханиад, улаан эсэргэнэ, менингококкт халдвар, аденовирүсийн халдвар, Haemophilus influenzae-р үүсгэгдсэн халдвар, микоплазмаар үүсгэгдсэн

халдвар MERSCO, АЦХаХ, КОВИД-19, гахайн хавдар зэрэг) үүсгэгч, тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед халдварын сэргийлэлт хяналтын болон халдвартын эмчийн мэргэжлийн, тархвар судлалын анхан шатны арга хэмжээ

Тойролт 2: Гэдэсний халдварт өвчин

Монгол улсад болон дэлхий дахинаа тохиолдож буй гэдэсний халдварт өвчин буюу хоол хүнс, усаар дамжин тархдаг халдварт өвчний (вирус, бактери, шимэгч гэх мэт халдвар үүсгэгчийн шалтгаант урвах тахал, хоолны хордлогот халдвар, балнад болон иж балнад, салмонеллез болон салмонеллийн халдвар, цусан суулга, эшерихийн халдвар, кампилобактерийн халдвар, гэдэсний иерсиноз, хоолны хордлого, хиамдил, амебиоз, ротавирус халдвар, халдварт саа, энтеровирус халдвар, цочмог вирус хепатит А,Е, шимэгчийн халдвар) үүсгэгч, тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед халдварын сэргийлэлт хяналтын болон халдвартын эмчийн мэргэжлийн, тархвар судлалын анхан шатны арга хэмжээ

Тойролт 3: Насанд хүрэгчдийн хепатит /цочмог/

Хепатитийн А, В, С, D, Е болон бусад вирусийн шалтгаант элэгний цочмог үрэвслийн насанд хүрэгчдэд тохиолддог хэлбэрийн шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт

Тойролт 4: Хүүхдийн цочмог хепатит

Хепатитийн А, В, С, D, Е болон бусад вирусийн шалтгаант элэгний цочмог хүүхдэд тохиолддог хэлбэрийн шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт

Тойролт 5 : Архаг вирус хепатит

Хепатитийн А, В, С, D, Е болон бусад вирусийн шалтгаант элэгний архаг үрэвслийн шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт

Тойролт 6: Зоонозын халдвар

Зонхилон болон шинээр тохиолдож буй зоонозын халдвар (бруцеллез, боом, тарваган тахал, галзуу, татран, шүлхий, хачигт халдвар, шимэгчийн халдвар, лептоспироз, гэдэсний иерсиноз, хуурамч сүрьеэ, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, ку халууралт, хачигт энцефалит, токсоплазмоз, бабезиоз)- ын үеийн тусламж үйлчилгээ шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн арга хэмжээ

Тойролт 7 : Тууралтат халдварт өвчин

Зонхилон болон шинээр тохиолдож буй тууралтаар илэрдэг халдварт өвчний (улаан бурхан, улаанууд, салхин цэцэг, улаан эсэргэнэ, херпесийн халдвар, менингококкт халдвар, ёлом, розеола бактерийн шалтгаант арьсны үрэвсэлт өвчнүүд, гар хөл амны өвчин, халдварт эритема, герпангина, энтеровирусийн шалтгаант тууралтат халдвар)- ын үеийн тусламж үйлчилгээ шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг

физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн арга хэмжээ

Тойролт 8 : Халдварын сэргийлэлт хяналт

Эмнэлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын төдийгүй ЭТҮХХ-ын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн арга хэмжээ, ХСХ-тай холбоотой хууль эрхзүйн баримт бичгийн тухай орчин үеийн арга хэмжээ

Тойролт 9 : Бэлгийн замаар дамжих халдвар /ХДХВ/ДОХ

Монгол улс болон дэлхий дахинаа зонхилон болон шинээр тохиолдож буй Бэлгийн замаар дамжих халдвар тэмбүү, заг хүйтэн, хламидийн халдвар, трихомониаз, бэлгийн херпес, ХДХВ/ДОХ-ын шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт

Тойролт 10 : Сүрьеэ

Сүрьеэ өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, уушгины анхдагч сүрьеэ, насанд хүрэгчдийн анхдагч сүрьеэ, ОЭТС бусад эрхтэний сүрьеэ, шалтгаан, тархвар судлал, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, хяналт, сэргийлэлт, халдварын сэргийлэлт хяналт, оношилгооны дэвшилтэт технологи

Тойролт 11 : Шинэ болон сэргэж буй халдвар

АЦХаХ, Коронавирусийн халдвар MERS-CoV, КОВИД-19, томуугийн цартахлын вирусийн халдвар, эмэнд тэсвэртэй бактери вирус мөөг шимэгчийн халдвар, Эбола, Зика вирусийн халдварын шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн арга хэмжээ

Тойролт 12: Хүлээн авах яаралтай тусламж

Халдварын сэжигтэй тохиолдолын оношилгоо, ялган оношилгоо, яаралтай тусламж, тусгаарлалт, сэргийлэлт, бүртгэл мэдээлэл, халдварын сэргийлэлт хяналтын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн арга хэмжээ

Тойролт 13: Халдварт өвчний үеийн эгзэгтэй байдал

Халдварт өвчний үеийн сонгодог хүндрэл болох халдвар хордлогын шок, элэгний цочмог дутал, шингэн алдалт, шингэн алдалтын шок, цус алдалт, мэдрэлийн хордлого, үжил, эрхтэний дистресс хамшинж зэрэг эгзэгтэй байдлуудын шалтгаан тархвар судлал, эмгэг жам, эмгэг анатоми, эмгэг физиологи, эмнэлзүй, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээ, сэргийлэлт, хяналт, тухайн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт, эмэнд тэсвэржилт

Тойролт 14: Арьсны өвчин

Хамуу, мөөгөнцрийн халдвар, арьсны үрэвсэлт өвчнүүд, халдварын бус шалтгаант арьсны өвчин

Тойролт 15: Дүрс оношилгоо

Уушгины рентген, хэвлийн хөндийн ЭХО зураг дүрс

Тойролт 16: Хүүхдийн өвчин

Халдварын бус шалтгаант хүүхдийн шарлалт, суулгалт, амьсгалын эрхтэний эмгэг болон нярайн эмгэг

Тойролт 17: Дархлал судлал

Дархлал судлалын ерөнхий ойлголт, халдварт өвчний үеийн дархлал тогтоц

Тойролт 18: Бичил амь судлал

Халдварт өвчнийг үүсгэгч бичил биет, түүний эмэнд тэсвэржилт

Тойролт 19: Хавдар судлал

Хоол боловсруулах эрхтэн (элэг, нарийн болон бүдүүн гэдэс), уушги, элэгний хорт хавдар

Тойролт 20: Дотор судлал

Тунгалагийн булчирхайн эмгэг, цусны эмгэг, чихрийн шижин, халдварын бус шалтгаант уушгины эмгэг

Тойролт 21: Эмнэлзүйн эм судлал

Халдварт өвчний үеийн үүсгэгчийн эсрэг эм, тэдгээрийн хоорондын зохицол

Тойролт 22: Халдварт өвчний диспансерчлал буюу хяналт

Халдварт өвчний үеийн хяналт түүнтэй холбоотой заавар, журам, дүрэм

Загвар 1**Ажлын байрны сургалт (On the job training)**

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч, хэрэглэгдэхүү	Удирдагч, хамтрагч
Ганцаарчилсан үзлэг, тойролтын хувиарын дагуу	1	Ажлын 3 цаг, өдөр бүр	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Хяналтын тойрон үзлэг	3-5	1 цаг, өдөр бүр	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Сургалтын тойрон үзлэг	20 хүртэл	2 цаг, 14 хоногт 1 удаа	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Зөвлөх үзлэг	1	Тохиолдол байгаа үед	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Гардан үйлдэл хийх	1	Тохиолдол байгаа үед	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш

Их эмчийн үзлэг, тойролтын хувиарын дагуу:

Суралцагч өдөр бүр тойролтын хувиарын дагуу 3-5 өвчтөнд их эмчийн үзлэг хийж оношийг тогтоож, эмчилгээг төлөвлөж, зөвлөгөө өгнө. Тохиолдол бүрийн үзлэгийн үр дүнг эмнэлзүйн сургагч багшид хянуулна.

Хяналтын тойрон үзлэг:

Суралцагч эмнэлзүйн сургагч багшид бусад суралцагчийн хамт өдөр бүрийн үзлэгийн үр дүнг танилцуулж, эмнэлзүйн сургагч багшийн хяналтын тойрон үзлэгт оролцоно

Сургалтын тойрон үзлэг:

Тойролт хийж буй тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 1 тохиолдлыг сонгон авч эмнэлзүйн сургагч болон бусад суралцагчдад танилцуулж онолын мэдлэг хуваалцах хэлэлцүүлэг хийнэ.

Зөвлөх үзлэг:

Яаралтай тохиолдолд суралцагч бусад эмч нарын хамтарсан үзлэгийг эмнэлзүйн сургагч багшийн хяналтын дор зохион байгуулах, оролцоно.

Загвар 2

Танхимын сургалт (*Off the job training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Ажлын бус цагаар	Тохиромжтой газар	Ном, сэтгүүл, цахим	Өөрөө, хамтран суралцагч нар
Лекц	20 хүртэл	2 цаг, 7 хоногт 1 удаа	Анги танхим	Үзүүлэн таниулах материал, видео	Сургагч багш, суралцагч нар
Журнал клуб	20 хүртэл	2 цаг, 14 хоногт 1 удаа	Анги танхим	Эмнэлзүйн тохиолдол, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл	Сургагч багш, суралцагч нар
Симуляци (дууриамал орчин)	20 хүртэл	2 цаг сард 1 удаа	Эмнэлгийн тасаг, амбулатори, яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч нар, манекин	Сургагч багш Хамтран суралцагч нар

Загвар 3

Үйл ажиллагааны хувиарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
- 8.30					
8:30-9:30	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг
9:30 -12:00	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
13:00-15:00	Лекц, семинар			Симуляци	Журнал клуб
16:00-17:00			Сургалтын тойрон үзлэг		

Бие даан суралцах (*Self-Development Training*) сурах бичиг, мэргэжлийн сэтгүүл, олон улсын сайт зэргийг ашиглан халдварт өвчний талаарх шинжлэх ухааны мэдээлэл болон холбогдох хууль, дүрэм, журам зэрэг мэдээлэлтэй танилцан бие даан суралцаж халдварт өвчин судлалын чиглэлээр орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтаар мэдлэгийн хүрээг тэлж түүнийгээ өдөр тутмын өвчтөний асуудал шийдэх, дадлага семинарын хичээлийн хамтарсан сургалт, симуляци, журнал клуб болон мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээл туурвилах, халдварт өвчтэй тохиолдолд зөвлөгөө өгөх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг үйл ажиллагаанд ашиглах, мөрдлөг болгоно. Тойролтонд заагдсан мэргэжлийн чиглэлүүдээр e-learning сургалтын сайтыг ашиглан суралцана.

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ ЭРГЭН ЗӨВӨЛГӨӨ

7.1. Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрийн ахиц дэвшилийн талаар болон суралцагчийн сарын төлөвлөгөөний талаар (*career plan*) талаар зөвлөн туслах үүрэг бүхий хариуцагч (*mentor*) –ийг томино. Сургалтын эхэнд суралцагч хариуцагчтай уулзах ба сар тутам 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж эргэн зөвөлгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэлзүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Эмнэлзүйн сургагч багш өдөр тутам суралцагчтай өдөр тутам тойролтын хугцаанд хамтран ажиллаж зөвлөн тусалж, хянана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3 Үнэлгээний арга

7.3.1 Төгсөлтийн шалгалт

Сургалтын төгсгөлд төгсөлтийн шалгалтыг онолын болон дадлага шалгалт гэсэн 2 хэлбэрээр өгч, тэнцсэн тохиолдолд “Халдварт өвчин судлалын эмч” үндсэн мэргэшлийн үнэмлэх олгоно.

7.3.2 Ажлын байранд-суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

360 хэмийн үнэлгээ (*360-Degree Assessment*):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (*Mini-Clinical Evaluation Exercise*):

Зайлшгүй таньж мэдэх 9 хамшинжээс тойролт бүрт 1-ээс доошгүй хамшинжийг тус бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно.

(Жишээ нь: Дотрын тойролтод халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол хүүхдийн тойролтод ч халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно).

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Гардан үйлдлийн үр чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills):

Зайлшгүй сурах 22 гардан үйлдлээс 11-ээс доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана.

Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 22 шинж тэмдгээс 1 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
 - ✧ Эмнэлзүйн тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 20-иос доошгүй удаа үзэж (халдварт өвчний тохиолдлоос хамааран тоо хэлбэлзэнэ), туршлага хуримтлуулсан байна.
 - ✧ Сургалтын эхний 1 жилийн турш зайлшгүй суралцах 10 төрлийн тохиолдол бүрийг оношилж, анхан шатны тусламж үзүүлсэн байна.
 - ✧ Зайлшгүй суралцах 22 гардан үйлдлээс 1 жилийн турш 15-аас доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

(хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалтын албаны мэргэжилтэн, тасгийн эрхлэгч, эмнэлзүйн сургагч багш, хариуцагч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь сургалт эрхлэх байгууллагын удирдлагын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь улирал бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (*Faculty Development*), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.3 Сургалтын танилцуулга (*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (*Program*) болон хөтөлбөрийн (*Curriculum*) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ,

оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Хавсралт 1

360 хэмийн ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийгч: О Эмнэл зүйн сургагч багш О Сувилагч О Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласанаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3		<input type="checkbox"/> 4	
Үнэлэх боломжгүй	Ховор (≥19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)		Бараг бүгд (≥80%)	
Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаан нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	<input type="checkbox"/> 4

Орон нутаг дах бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх гусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: "Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?"

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр /

/

Суралцагч эмчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Клиник Тасаг ЯТТ

Бусад _____ өвчтөний нас: _____ өвчтөний хүйс: Эр Эм

Өвчтөний зовиур: Халуурах Шарлах Толгой өвдөх Ухаан санааны байдал өөрчлөгдөх

Татах Амьсгаадах Ханиах Цээжээр өвдөх Зүрх зогсох Цустай бөөлжих Цустай хар

өтгөн гарах Дотор муухайрах/Бөөлжих Хэвлийгээр өвдөх Суулгах Усгүйжих Нуруу өвдөх

Саажих Сэтгэл гутрах Хавагнах Үе өвдөх Лимфийн булчирхай томрох Цус алдах

Бусад _____

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү. Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: <input type="checkbox"/>			
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг Суралцагч эмчийн гарын үсэг

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Өвчний түүх авах	<ul style="list-style-type: none"> • Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. • Өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг. • Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> • Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. • Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> • Зөв онош тавидаг. • Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг. • Тохирсон эмчилгээг эхлүүлдэг. • Тохирсон тасаг эмнэлэгт шилжүүлдэг цааш нь хяналт тавьдаг
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> • Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. • Өвчтөний таатай байдал, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвхи зүтгэл гаргадаг. • Халдварын сэргийлэлт хяналтын дүрмийг мөрддөг • “Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна!”

Хавсралт 3

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он сар өдөр

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: Газар: Клиник, Тандалтын нэгж ЯТТ

Гардан үйлдэл: Амьсгалын зам чөлөөлөх, Зүрх, уушгины сэхээн амьдруулалт(насанд хүрэгч), Зүрх, уушгины сэхээн амьдруулалт (хүүхэд), Дефибрилляц хийх, Артерийн судсанд гуурс тавих, Төвийн судсанд гуурс тавих, Цээжинд гаргуур тавих, Ходоодонд хаймсуур тавих, Давсанд гуурс тавих,

Блекморын зонд тавих, Зохиомол амьсгалд өвчтөн оруулах ба гаргах

Хүзүүний бэхэлгээ хийх Нуруу нугасны гэмтэлтэй өвчтөний бэхэлгээ хийх,

Монитор бэлтгэх, Интубац тавьж мэдээ алдуулах, Төвөнхийн углавчтай мэдээ алдуулах,

НХМА, НГХМА, Захын мэдрэлийн хориг, Хяналтын хуудас бөглөх, Хэт авиан түргэвчилсэн оношилгоо, хяналттай ажилбарууд гүйцэтгэх,

Бусад _____

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо

Үнэлгээ	Хангалтгүй	Завсарын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ үйлчлүүлэгчид тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэлийн бэлтгэлийн аюулгүй байдлыг хангаж чаддаг				
Үйлдлийн үед халдварын сэргийлэлтийн дүрмийг мөрддөг				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				

Гардан үйлдэлд ашигласан багаж хэрэгслийг халдварын сэргийлэлт хяналтын дүрийн дагуу устгал, халдваргүйжүүлэлт хийдэг				
Гардан үйлдлийн үр дүнгийн талаар үйлчлүүлэгчид зохистой мэдээлдэг				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд зөв хөтөлдөг				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				
Гардан үйлдэл хийх багийн гишүүдтэй ёс зүйтэй харьцдаг				

Зөвлөмж:

* Сайн тал;

* Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагч эмчийн гарын үсэг: _____

НОМ ЗҮЙ

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/447 дугаар тушаал “Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”
2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/337 дугаар тушаал “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох “ журам
3. ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтэний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 6-р сарын 3-ны өдрийн хурлын №1 тогтоол “Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага батлах тухай”
4. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн А/226 дугаар тушаал “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам”
5. Олон улсын өвчний 10-р ангилал <https://www.icd10data.com/ICD10CM/Codes>
6. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, 2017-2021 он
7. Халдварт өвчин сурах бичиг, 2021 он
8. <https://www.who.int/>
9. <https://www.cdc.gov/>
10. <https://moh.gov.mn/>
11. <http://hdc.gov.mn/>